

МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН
ХАНГАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

WAYS TO IMPROVE THE EFFECTIVENESS OF INFORMATION SECURITY FORENSIC EXPERT
PERFORMANCE IN MONGOLIA

Баяндоржийн Цолмон

ОХУ-ын ДХЯ-ны Москвагийн их сургуулийн адъюнкт, цагдаагийн дэд хурандаа,
утас: +7(909)662-48-29, цахим шуудангийн хаяг: f65gd@yandex.ru.

Tsolmon Bayandorj

adjunct Moscow State University Russian Interior Ministry.
Tel. № +7 (909) 662-48-29, и-мэйл: f65gd@yandex.ru

Мэргэшлийн чиглэл: 12.00.12 - криминалистик, шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа, гүйгэтгэх ажлын үйл ажиллагаа.

Scientific specialty: 12.00.12 - criminalistics; forensic-expert activities; operatively-search activity.

Эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар хүн төрлөхтөний өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох гол хүчин зүйлийн нэгд мэдээлэл, түүгээр хангахтай холбоотой үйл ажиллагаа зүй ёсоор тооцогдох болжээ. Тухайлбал, ОХУ-ын эрдэмтэн М.В. Вальяногийн тэмдэглэснээр, “XXI зууны эхэнд улс орны хөгжлийн түвшинг тодорхойлохдоо барилга байгууламжийн хэмжээ, танк болон пуужингийн тоо, урлаг соёлын амжилт зэргээр бус харин эд баялаг, ахиц дэвшлийн гол нөхцөл нь мэдээллийг хүлээн авах, боловсруулах ба дамжуулах салбарын инноваци болоод байна” гэжээ [1].

Өнөөдөр “мэдээлэл” гэсэн нэр томъёоны тодорхойлолт нэг мөр жигдрээгүй байгаа хэдий ч, орчин үеийн шинжлэх ухааны нийтлэг ойлголтоор түүний утгыг дараах байдлаар тайлбарлаж байна. Үүнд: мэдээлэл нь хүмүүс хоорондын төдийгүй нийгэм, эдийн засгийн, эрх зүйн харилцааг зохицуулах хэрэгслэл, мөн мэдлэг, танин мэдэхүйн, судлагаа шинжилгээний объект, цаашлаад аливаа үйл явц, юмс үзэгдлийн материаллаг болон материаллаг бус биетийн илэрхийлэл зэргээр асар өргөн цар хүрээг хамарч байна.

Мэдээлэлтэй холбоотой үйл явц нь Монгол Улсын нийгмийн харилцааны бүхий л салбарыг мөн адил хамраад байгаагийн дотроос шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа үүнд тодорхой байр суурийг эзлэх боллоо. Учир нь олон зүйлийн агуулга, хэлбэр бүхий тус салбарын үйл ажиллагааг автоматжуулалт болон мэдээлэлжүүлэлт үгүйгээр төсөөлөхийн аргагүй юм. Тухайлбал, аливаа хэрэг, зөрчил, маргааныг шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотолгооны бүрдэлтийн зонхилох хувийг шүүхийн шинжилгээ эзэлдэг. Тэгвэл шинжилгээний ашиглах цар хүрээ, ач холбогдол нь өсөн нэмэгдэхийн зэрэгцээ түүний чанар, үр дүнд тавигдах шаардлага мөн дээшилсээр байна. Үүнд эерэгээр нөлөөлөх гол хүчин зүйлийн нэгд шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалт зүй ёсоор тооцогдох боллоо.

Энэ талаар ОХУ-ын нэрт эрдэмтэн Н.П. Майлис дурьдахдаа: “Энэхүү хөгжингүй болоод боловсронгуй тогтолцоо нь шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны субъектүүдийг зохих мэдээллээр хангахыг шаардана. Энэ нь угтаа шинжилгээний байгууллагуудын шийдвэрлэж байгаа олон талын зорилттой нийцэхийн зэрэгцээ мөн уг үйл ажиллагааны олон талын хэлбэртэй тохирч байх ёстой” гэсэн байна [2].

Уг онол нь гадаадын өндөр хөгжилтэй олон орнуудын, түүн дотроос ОХУ-ын шүүхийн шинжилгээний практикт өргөн нэвтрээд байна. Учир нь шүүхийн шинжилгээний, түүний дотроос криминалистикийн шинжлэх ухааны онолыг боловсруулахад оросын эрдэмтэд жинтэй хувь нэмэр оруулдаг. Иймд Монгол Улсын шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтыг бүрдүүлэх, түүнийг боловсронгуй болгоход, тус улсын дэвшилт арга барил, оновчтой туршлагыг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Судлаж буй асуудлын ач холбогдол, цар хүрээг харгалзан түүнийг дараах чиглэлээр цогц авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд: онол, арга зүй, хууль, эрх зүй, удирдлага, зохион байгуулалт зэрэг багтана.

Онол, арга зүйн чиглэлээр:

Дээр товч дурьдсанаар шинжилгээний ач холбогдол, түүний ашиглах цар хүрээ өсөн нэмэгдэхийн хэрээр түүнд тавигдах шаардлага дээшилж байна. Үүнд: Нөлөөлж буй гол хүчин зүйлд зөвхөн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд төдийгүй, шүүхийн шинжилгээний салбарт хурдацтай нэвтэрч байгаа мэдээлэлжүүлэлт, шинжлэх ухааны мэдлэгийн нэгдэл /интеграци/, ялгарал /дифференциаци/ зэрэг үйл явцуудыг мөн адил хамаарна. Тухайлбал: Шинжээчийн дүгнэлтийг зөвхөн эрүүгийн хэрэг болон захиргааны зөрчлийг бус аливаа хэрэг, маргааныг шүүхийн бусад хэлбэрээр хянан шийдвэрлэхэд нотолгооны хэмжээнд мөн адил үнэлж, дүгнэж, ашиглахад чиглэгдэх ёстой.

Иймд Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагад криминалистикийн /гэмт хэрэг судлалын/ шинжилгээнээс гадна өөр олон төрлийн шинжилгээг практикт нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна¹. Энэхүү үйл явцтай уялдан шүүхийн шинжилгээний ерөнхий онолын үндэс тавигдаж улмаар шүүхийн шинжилгээ шинжлэх ухааны бие даасан салбарын нэг болоод байна.

Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтын үр нөлөөг дээшлүүлэхэд тус салбарын онолын салшгүй хэсгийн нэг болох хэл зүй чухал үүрэгтэй. Тэгвэл түүний түвшинг тодорхойлох гол шалгуур нь зөв оноож тогтоосон нэр томъёо юм. Энэ тухай ОХУ-ын нэрт эрдэмтэн Т.В. Аверьянова тэмдэглэхдээ, “шүүхийн шинжилгээний ерөнхий онолын хөгжил, боловсронгуй болгоход түүний нэр томъёог мөн адил хөгжүүлж боловсронгуй болгохоос ихээхэн хамааралтай гэж тодорхой хэлж болно” гэжээ [3].

Энэхүү үзэл санаа нь Монгол Улсын шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд мөн адил хамааралтай юм. Учир нь мэдээлэлжүүлэлтийн үйл явцтай уялдан тус салбарт хүч түрэн нэвтэрч байгаа шинэ ойлголт, нэр томъёонуудыг үгийн сангийн дүрмийн шаардлагад нийцүүлэн цэгцэлж эрэмблэх, цаашлаад шүүхийн шинжилгээний ойлголт нэр томъёог нэгдсэн тогтолцоонд оруулах асуудал мөн тулгамдсан зорилтын нэг болоод байна. Үүнд дараах ойлголт, нэр томъёонуудыг нэрлэж болох юм. Жишээлбэл: “Мэдээлэл”, “мэдээллийн сан”, “криминалистикийн тоо бүртгэл”, “шинжээчийн дүгнэлт”, “шүүхийн шинжилгээний тухай хууль”, “шүүх эмнэлэг”, “ерөнхий болон хувийн шинж тэмдэг”, “зөвшөөрсөн болон татгалзсан дүгнэлт” гэх мэт ойлголтуудын утга, тэдгээрийн хэрэглээний үүрэг, чадамжийг шинжлэх ухааны онолын үүднээс судлах шаардлагатай болоод байна.

Уг асуудлаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч, мэргэжилтэн нарын дунд явуулсан санал асуулгын үр дүнгээс харахад, судлагаанд оролцогсодын 75 хувь нь шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтыг боловсронгуй болгоход ойлголт, нэр томъёо чухал үүрэгтэй гэсэн хариултыг сонгосон байна.

Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтын үр ашгийг дээшлүүлэхэд нөлөөлөх өөр нэг чухал хүчин зүйл нь шүүхийн шинжилгээний арга зүй юм. Учир

¹ Энэ үүднээс шинжилгээг “шүүхийн” гэсэн тодотголтойгоор томъёолох нь зүйд нийцнэ гэж үзэж байна. Б.Ц.

нь мэдээллээр хангах үйл явц нь тухайн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах, үнэлж дүгнэх, дамжуулах, ашиглах зэрэг дэс дараатай, олон талын, цогц ажиллагаанаас бүрдэнэ.

Тэгвэл уг үйл ажиллагааны эцсийн үр дүн нь тухайн салбарын субъектүүд болох шинжээч, мэргэжилтэн болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, өмгөөлөгч нарыг шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Иймээс уламжлал болж хоцорсон шинжилгээ судлагааны арга барилуудаас салж, шүүхийн шинжилгээний практикт инновацийн түвшинд шинэ арга, аргачлалыг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тухайлбал: ОХУ-ын эрдэмтэн Е.А. Зайцевагийн тайлбарласнаар, “шүүхийн үйл ажиллагааны хэлбэрээс /иргэний, захиргааны, эрүүгийн, арбитрайн/ үл хамааран шинжилгээний үйл ажиллагаа өөрийн гэсэн нийтлэг арга зүй дээр суурилсан байх ёстой. Үүний баталгаа нь шинжилгээний төв байгууллагуудаас уламжлал болгон хэрэгжүүлдэг шинжилгээний арга зүй, аргачлалын баталгаажуулалт, стандартчлалт юм” гэжээ [4].

Энэ чиглэлийн арга хэмжээ нь Монгол Улсын шүүхийн шинжилгээний өнөөгийн үйл ажиллагаанд үгүйлэгдэж байна. Энэ тухай Б. Бат-Эрдэнэ тэмдэглэхдээ: “Монгол Улсын шинжилгээний байгууллагын тогтолцоонд, тэр тусмаа сүүлийн жилүүдэд олон улсын шинжилгээний практикт шинэ төрлийн шинжилгээ идэвхтэй өсөж хөгжин, боловсронгуй болж байгаа энэ цаг үед шинжилгээний арга, аргачлалыг боловсруулах, нэвтрүүлэх чиглэлд, түүнийг хариуцсан шинжлэх ухааны, шинжлэх ухаан судлалын болон шинжлэх ухаан туршилтын зэрэг нэгжүүд урьд өмнө ч, өнөөгийн нөхцөлд ч хэзээд оршиж байгаагүй байсаар ирсэн” гэжээ [5].

Дээрхи төлөвөөс харахад, шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтын үр ашгийг дээшлүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйлд нэр томъёо, шинжилгээний арга зүй, аргачлал тооцогдохын зэрэгцээ, мөн тэдгээрийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтыг боловсронгуй болгоход мөн хууль, эрх зүйн орчин чухал үүрэгтэй юм.

Учир нь өнөөдөр “мэдээллийн эрх зүй”, “мэдээллийн хууль тогтоомж”, “иж бүрэн мэдээллийн хууль тогтоомж”, “мэдээллийн нэгдсэн тогтолцоо” зэрэг ойлголт, нэр томъёонууд олон улсын эрх зүйн тогтолцоонд нэг мөр нэвтрээд байна. Манай улсын хувьд энэ чиглэлд тодорхой ахиц дэвшил гарч байгаа хэдий ч мэдээллийн харилцааг цогцоор нь зохицуулах хууль, эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байна гэж үзэх талтай.

Үүнийг мэдээллийн хангалт, хамгаалалт, аюулгүй байдалтай холбоотой харилцааг зохицуулах талаар өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа мэдээллийн болон салбарын хууль тогтоомж, эрх зүйн актуудад зохих тусгалаа олоогүйтэй холбоотой юм.

Үүний үр дагавар нь мөн шүүхийн шинжилгээний салбарт илүү ихээр нөлөөлж байна. Тухайлбал, энэ талаар доктор Т.Бямбаа бичихдээ: “Дээрхи хууль тогтоомжийн заалтууд нь криминалистикийн түүн дотроос гарын дардас судлалын бүртгэлийн үндэс ямар нэгэн байдлаар болох хэдий ч, харин тэдгээр нь хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн бүртгэлийн бүрдүүлэлт, хөтлөлт, ашиглалттай холбоотой үйл ажиллагааг нэг мөр зохицуулах боломжгүй юм” [6] гэсэн бол үүнийг баталж Б. Бат-Эрдэнэ: “... ийм байдлаар дүн шинжилгээ хийх шаардлага аль хэдийнээ үгүйлэгдэж байсан бөгөөд зөвхөн эрх зүйн актуудын олон төрлөөс бус, угтаа эдгээр хууль тогтоомжуудын заалтууд нь өөр хоорондоо туйлын хангалтгүй уялдаа холбоотой байгаатай холбоотой юм” гэж оновчтой тэмдэглэжээ [5].

Үүний тод илрэл нь тус салбарын мэдээллийн хангалтын талаар Шүүхийн шинжилгээний тухай Монгол Улсын Хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь улсын хэмжээний шүүхийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сантай байна” гэсэн бол, уг зүйлийн 2 дахь хэсэгт: “Шүүхийн

шинжилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” [7] гэж тус тус заасан байна. Үүнээс харахад мэдээллийн хангалттай холбоотой харилцааны зохицуулалт ерөнхий буюу хангалтгүй байдлаар тусгалаа олсон байдал ажиглагдаж байна.

Иймд шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтыг хэрэгжүүлэх явцад үүсэх харилцааг холбогдох байгууллагын дүрэм, журам, заавраар зохицуулахад хүрээд байна.

Тэгвэл уг харилцааг гадаадын зарим орнуудын хуулиар хэрхэн зохицуулсаныг товч авч үзье. Тухайлбал: “Оросын Холбооны Улс дахь шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай” Холбооны Хуулийн 39 дүгээр зүйлд: “Байгууллага бүр өмчийн болон зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрээс үл хамааран төрийн шүүхийн шинжилгээний байгууллагын хүсэлтийг үндэслэн шүүхийн шинжилгээ явуулахад шаардлагатай өөрийн бүтээгдэхүүний загвар, техник, технологийн баримт бичиг болон мэдээлэлтэй холбогдолтой бусад материалуудыг буцаан олгох болон нэхэмжлэх нөхцөлгүйгээр гарган өгч байх үүрэгтэй...” гэж заажээ [8]. Мөн хуулийн 5 дахь заалтанд гадаадын орны шинжээч, мэргэжилтэн нарыг шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд татан оролцуулах харилцааг мөн зохицуулсан байна. Утга, агуулгын хувьд эдгээртэй төстэй заалтууд мөн Казахстан, Беларусь, Молдов зэрэг улсын шүүхийн шинжилгээний хууль, тогтоомжуудад тусгалаа олсон байна.

Дээрхи байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, мэдээллийн хангалттай холбоотой харилцааг зохицуулах энэ мэт заалтууд Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулинд зайлшгүй шаардагдаж байна. Үүнийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн /цаашид ШШҮХ гэх/ шинжээч, мэргэжилтэн нарын дунд явуулсан санал асуулгын үр дүн мөн баталж байна. Судлагаанд хамрагсадын 62 хувь нь шүүхийн шинжилгээний мэдээллийн хангалтын үр нөлөөг дээшлүүлэхэд, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзжээ.

Удирдлага, зохион байгуулалтын хувьд

Шүүхийн шинжилгээний үйд ажиллагааны мэдээллийн хангалтын үр нөлөөг дээшлүүлэхэд зөв удирдлага, зохион байгуулалт мөн чухал үүрэгтэй юм. Үүний тулд мэдээллийн эх сурвалжуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тогтоох, үүнд түшиглэн шүүхийн шинжилгээний мэдээллийн санг нэгдсэн тогтолцоонд оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсын шүүхийн шинжилгээний практикаас харахад уг чиглэлд мэдээллийн хангалт хариуцсан мэргэжлийн чиг үүрэг бүхий үйл ажиллагаа энд үгүйлэгдэж байна. Үүний нэг илрэл нь шүүхийн шинжилгээний мэдээллийн чанар, үр ашиг нь өнөөгийн шаардлагад хүрэхгүй байгаатай холбож болох талтай. Тухайлбал, үүний баталгаа нь, санал асуулганд хамрагсадын 54 хувь нь ШШҮХ-ийн автоматжуулсан мэдээллийн систем дэх мэдээллийн чанарт хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн явдал юм. Мөн түүнээс гадна, энэ чиглэлд удирдах бүрэлдэхүүний дэмжлэг, оролцоог дээшлүүлэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулах, судлагаа шинжилгээний ажлыг, сурах бичиг, гарын авлага, зөвлөмж гаргах, бусад албадын болон улсын байгууллагуудтай уялдаа холбоо, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зэрэг олон талын арга хэмжээ шаардагдаж байна.

Санал

Дээр дурьдсанд тулгуурлан, Монгол Улсын шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шинжлэх ухааны онол, арга зүйн хүрээнд:

- шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтыг шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан судлаж, практикт нэвтрүүлэх,

- шүүхийн шинжилгээний салбарт хэрэглэж байгаа ойлголт, нэр томъёонуудыг боловсронгуй болгоход чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2. Хууль, эрх зүйн хүрээнд:

- Шүүхийн шинжилгээний тухай Монгол Улсын хуульд шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалттай холбоотой харилцааг зохицуулах заалтыг нэмж тусгах
- мэдээллийн салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудыг нэгтгэн нэгдсэн тогтолцоонд оруулах.

3. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

- шинжилгээний мэдээллийн хангалт хариуцсан мэргэжлийн алба байгуулж, шүүхийн шинжилгээний байгууллагын бүтцэд хамааруулах,
- шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн хангалтын чиглэлээр гарын авлага, аргачлал, зөвлөмж гаргах,
- шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны мэдээллийн системийг нэгдсэн тогтолцоонд оруулах.

Дүгнэлт

Өнөөгийн нөхцөлд шүүхийн шинжилгээний ашиглах цар хүрээ өргөжин тэлэхийн зэрэгцээ түүнд тавигдах шаардлага, ач холбогдол нь мөн өсөн нэмэгдсээр байна. Үүнд нөлөөлөх гол хүчин зүйлийн нэгд мэдээлэл, түүгээр хангахтай холбоотой үйл ажиллагаа зүй ёсоор тооцогдох боллоо. Иймд уг үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх асуудал Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын тулгамдсан зорилтын нэг болоод байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд, шинжлэх ухааны онол, арга зүйн, хууль эрх зүйн, удирдлага, зохион байгуулалтын зэрэг цогц арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Дээрхи чиглэлд оршиж байгаа тулгамдсан асуудлуудыг оновчтой гаргаж шийдвэрлэснээр, зөвхөн мэдээлэл түүгээр хангахтай холбоотой үйл ажиллагааг төдийгүй, шүүхийн шинжилгээний салбарыг бүхэлд нь боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Ашигласан ном зүй:

1. Вальяно М.В. История и философия науки: учебное пособие. – М: Альфа-М: ИНФРА-М. 2012. - 208 с. (Шинжлэх ухааны түүх, философи: сурах бичиг. М: Альфа-М: ИНФРА-М. хэвлэлийн газар 2012. - 208 х.).
2. Майлис Н.П. Руководство по трасологической экспертизе. М. 2007. - 344 с.
3. Аверьянова Т.В. Судебная экспертиза. Курс общей теории. /Т.В. Аверьянова. – М.: Норма. 2008. - 480 с
4. Зайцева Е.А. Концепция развития судебной экспертизы в условиях состязательного уголовного судопроизводства: Автореф. дисс. ... д-ра юрид. наук. М. 2008. - 60 х.
5. Бат-Эрдэнэ Б. Статус специалиста и эксперта в судопроизводстве Монголии: Дисс... канд. юрид. наук. М. 2009. - 185 с.
6. Бямбаа Т. Современное состояние и перспективы развития дактилоскопии и дактилоскопической регистрации в Монголии: Дисс. ... канд. юрид. наук. М. 2011. – 180 с.
7. Закон Монголии «О судебной экспертизе» от 3 декабря 2009 г. // «Государственный бюллетень» № 1. УБ. 2010.
8. Федеральный закон «О государственной судебно-экспертной деятельности в Российской Федерации» от 31 мая 2001 г. № 73-ФЗ //СЗ РФ от 04.06.2001 г., № 23. Ст. 2291.